



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

7 ДУГААР ЗҮЙЛ.

Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох





7.1 Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ **үгээр, биеэр, цахимаар** болон бусад аливаа хэлбэрээр дараах байдлаар **дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно:**

7.1.1 Зодох, цохих зэргээр бусдын **эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх**, үйлдэхээр заналхийлэх;

7.1.2 Хэл амаар **доромжлох, нэр төр**, алдар хүндийг гутаах;

7.1.3 Энэ хуулийн 6.1-д заасан хориглосон үндэслэлээр **ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх** замаар ажлын байрны тэвчишгүй орчныг үүсгэх.





7.2 Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ хүсээгүй байхад нь **бэлгийн сэдлээ үгээр, биеэр, цахимаар** болон бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн харилцаанд орох эсэхээс **шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс** зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар **урамшуулах, эсхүл хохироохоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, болзол тавих** /quid pro quo/ байдлаар бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно.





7.3 Ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд **дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртсөн** гэж үзвэл гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, **дээд шатны албан тушаалтан**, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. Гомдлыг хүлээн авах **байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг** ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй.





7.4 Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас **урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг** хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх үүрэгтэй.





7.6 Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд **дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үйлдсэн** этгээдэд **Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд** заасан хариуцлага хүлээлгэх бөгөөд ийнхүү хариуцлага хүлээлгэсэн нь **хөдөлмөрийн сахилгын шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.**

